



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 9/184

Цагаан-Уул сум

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичиг, тавигдах шаардлага тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд дарамт болж байгаа эсэх цагийн хуваарь шинэчлэн тогтоох асуудлаар хэлэлцүүлэг, сонсох ажиллагаа зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Алтанбаатар (Засаг даргын орлогч)

Гишүүд: А.Энхбаяр (Хэсгийн төлөөлөгч)

Д.Мөнхбат (Татварын Улсын байцаагч)

Б.Ичинхорлоо (Хууль эрх зүйн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: М.Оюунчимэг (Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн)

2. Цагийн хуваарийг шинэчлэн тогтоох талаар хэлэлцүүлэг зохион байгуулж тайлан мэдээг хугацаанд нь хийж хүргүүлэхийг ажлын хэсэг (Н.Алтанбаатар)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА

С.ГОНЧИГНЯМ



/Zahiramj 2024/